

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах*

*тухай хуулийн төсөл*

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжид 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан төсвийн цаглабрын дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газар 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлахаар тус тус заасан.

Иймд Төсвийн тухай хуульд “Төсвийн төслийг дахин мэдүүлж, батлах” гэсэн 32<sup>1</sup> дүгээр зүйлийг нэмж тусгахаар хуулийн төсөл боловсрууллаа.

### **32<sup>1</sup> дүгээр зүйл.Төсвийн төслийг дахин өргөн мэдүүлж, батлах**

-“32<sup>1</sup>.1.Улсын Их Хурал улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол Засгийн газар холбогдох төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Энэхүү зохицуулалтаар Улсын Их Хурал Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэхээр тусгайлсан зүйлийг нэмэлтээр тусгалаа.

-32<sup>1</sup>.2.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан төсвийн төслийн танилцуулга, тооцоолол, судалгааг энэ хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсөвт үндэслэн боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тусгасан байна.

32<sup>1</sup>.3.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасны дагуу төсвийн төслийг өргөн мэдүүлэхдээ энэ хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй.

Төсвийн тухай хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн төсвийн тооцлол дээр үндэслэн нийт зарлага болон алдагдалыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг тусгалаа.

-32<sup>1</sup>.4.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасны дагуу өргөн мэдүүлэх төсвийн төсөлд энэ хуулийн 8.4, 8.5 дахь хэсэг, 28<sup>1</sup> дүгээр зүйл хамаарахгүй.

32<sup>1</sup>.5.Улсын Их Хурал энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан төсвийн төслийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батална.

Хуульд заасны дагуу тухайн жилийн төсвийн тухай хуулийг Улсын Их Хурал хүчингүй болгосон тохиолдолд яаралтай горимоор төсвийн төслийг өргөн мэдүүлэх шаардлагыг харгалзан Төсвийн тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан цаглабрыг мөрдөхгүй байхаар зохицууллаа.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*Танилцуулга:* Тус хуулийг дагаж мөрдөх хугацааг заасан.

---o 0o---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Төсвийн тухай хуульд нэмэлт  
оруулах тухай хуулийн төсөл*

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжид 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан төсвийн цаглабрын дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газар 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлахаар тус тус заасан.

Харин Улсын Их Хурал Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэх тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад заасан зорилгыг хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх эрсдэлтэй байх тул Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх нөхцөл үүсээд байна.

Иймд жилийн төсвийн төслийг Улсын Их Хурал хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газар төсвийн төслийг дахин боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, төсвийн төсөлд тусгах өөрчлөлтийн хүрээг тусгасан хуулийн төслийг боловсрууллаа.